



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 онь 08 сарын 01 өдөр

Дугаар А/474

Номгон


Шинээр гаргах уст цэгийн жагсаалтад  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.2, Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар "Шаардлагатай сумдад бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж худаг гаргах, засварлах тухай" 2023/36 тоот гэрээний 8 дахь заалтад тусгагдсан Баацагаан сумд гаргах уст цэгийн өөрчлөлтийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Инженерийн хийцтэй уст цэг гаргах ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг "Чорьж Бүрд" ХХК-д, ашиглалт хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллахыг Бууцагаан сумын Засаг дарга (Д.Лхагвадорж)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311067

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар  
сарын 01-ний өдрийн 1/41 дүгээр захирамжийн  
хавсралт

2023 ОНД ШИНЭЭР ГАРГАХ ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ  
УСТ ЦЭГИЙН ЖАГСААЛТАД ОРУУЛСАН НЭМЭЛТ  
ӨӨРЧЛӨЛТ

Д/д	Гэрээнд тусгагдсан сумын нэр	Уст цэг гаргах цэг	Цэг өөрчилсөн шалтгаан	Өөрчлөгдсөн цэг
1	Баацагаан сум	Буйлсан баг Довцог хонд	Геофизикийн хайгуул 2 удаа хийсэн боловч усгүй гарсан.	Бууцагаан сум Баянбүрд баг Цохио худаг

оОо